

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

Улаанбаатар хот

.....

Энэхүү гэрээг нэг талаас Улаанбаатар, дүүрэг, хороо, хороолол, байр, тоотод оршин суух - РД: / цаашид “Зээлдүүлэгч” гэх /, Нөгөө талаас хаягт оршин суух – РД: /цаашид “зээлдэгч” гэх / нар харилцан тохиролцож, Монгол улсын Иргэний хуулийн 281-285 дугаар зүйлүүдийг үндэслэн дараахь нөхцөлтэйгээр байгуулав.

1. Зээлдүүлэгч нь (..... зуу) төгрөгийг 20... оны ... сарын ... өдөр зээлдэгчид 20... оны ... сарын-ний өдөр хүртэл 2 (хоёр) сарын хугацаатайгаар зээлдүүлж байна.
2. Зээлдэгч нь төгрөгийг нэг сарын хувийн хүүтэй зээлэв.
3. Энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд барьцааны зүйл болгон _____ эд хөрөнгийг барьцаанд авч, Барьцааны гэрээг байгуулав.
4. Зээл авагч тал энэ гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ, хүүгийн хамт төлөх үүрэгтэй.
5. Зээлдэгч Гэрээнд заасан хугацаанд үндсэн зээлийг хүүгийн хамт төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданга төлнө.
6. Зээл авагч тал хугацаандаа авсан зээлээ буцаан төлөөгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссанаас хойш 7 хоног өнгөрмөгц Зээл өгөгч нь барьцаалсан хөрөнгийг хураан авч, захиран зарцуулж, түүний үнийн дүнгээс үндсэн зээл, хүү, алданги, хохирлоо гаргаж авах эрхтэй.
7. Барьцааны эд хөрөнгийг борлуулж энэ гэрээний 6-д заасан төлбөрийг барагдуулж дуусаад мөнгө үлдэх тохиолдолд зээлдэгчид буцаан өгнө.
8. Зээлдэгч нь авсан зээлийг хугацаанаас нь өмнө төлж болох ба 20... оны сарын-ны өдрийн дотор үндсэн зээл, тухайн сарын хүүг бүрэн төлсөн бол дараагийн сарын хүү төлөхгүй гэрээ дуусгавар болно.
9. Энэ гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
10. Зээл өгөгч гэрээнд заасан мөнгийг зээл авагчийн дансанд шилжүүлэн өгснөөр энэхүү гэрээг байгуулсанд тооцно.
11. Талууд гэрээний бүх нөхцлийг уншиж ойлгосон ба өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлж, харилцан тохиролцож байгуулсан болно.
12. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд гарын үсэг зуран нэг нэг хувийг хадгална.

.... Үргэлжлэл бий ...